**ГАЛТ ТЭРЭГНИЙ**
**ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН**
**НЭГДСЭН ТӨВИЙН ЗАХИРЛЫН**
**ТУШААЛ**

2021 оны 02 сарын 02 өдөр Дугаар А/13 Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.1, “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 6.9-д заасныг тус тус үндсэлэн ТУШААХ нь:

1. “ГТХЗНТ” УТҮГ-ын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр 2021 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөнд тусгагдсан ажлын гүйцэтгэл, үр дүнд хяналт тавьж ажиллахыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүргийг бүхий комисс (И.Банзрагч)-т, төлөвлөгөөний биелэлтийг зам, тээврийн салбарын ХАБЭА-н салбар хороонд хагас жил, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг комиссын нарийн бичгийн дарга (М.Оюун-Ундрам)-д тус тус даалгасугай.

ЗАХИРАЛ А.БУЯННЭМЭХ

ТТБ5680.5670225

000780

“Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирлын 2021 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/13 дугаар тушаалын хавсралт

“ГТХЗНТ” УТҮГ-ЫН ХЭМЖЭЭНД ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР 2021 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хийгдэх ажил | Хугацаа | Хариуцах албан тушаалтан | Дэмжлэг үзүүлэх албан тушаалтан | Хүрэх үр дүн |
|---|---|---|---|---|---|
| **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд** | | | | | |
| 1 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг сурталчлах, хэрэгжилтийг хангуулах чиглэлээр гарсан дүрэм, журам, зааврыг сурталчлан таниулах | Тухай бүр | ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжилтэн | ХАБЭА, ҮОХХСБКомисс | ХАБЭА-н тухай хуулийг сурталчилж, хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр гарсан дүрэм, журам, зааврыг мөрдүүлсэн байна |
| 2 | “ГТХЗНТ” УТҮГ-ын захиргаа, ажилтнуудын ҮЭХ хооронд байгуулах хамтын гэрээнд ХАБЭА-н үйл ажиллагааг тусгаж батлуулах | I улирал | ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжилтэн | ХАБЭА, ҮОХХСБКомисс | “ГТХЗНТ”УТҮГ-ын захиргаа, ажилчдын үйлдвэрчний эвлэлийн хороо хооронд байгуулах 2021-2025 онд хэрэгжих хамтын гэрээний төсөлд ХАБЭА-н асуудлыг тусгаж батлуулсан байна. |
| 3 | Эрүүл мэндийн тухай хуулийг сурталчлан таниулах | I улирал | ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжилтэн | ХАБЭА, ҮОХХСБКомисс | Эрүүл мэндийн хуулийн талаар сургалт мэдээлэл зохион байгуулж, мэдлэг олгосон байна |
| 4 | Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг сурталчлан таниулах, ажлын байрны болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон талт арга хэмжээ авах | II улирал | ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжилтэн | ХАБЭА, ҮОХХСБКомисс | Хуулийн сургалт мэдээллийн арга хэмжээг зохион байгуулж, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан байна |
| 5 | Ажилтанд анхан шатны, урьдчилсан, давтан зааварчилгааг хууль, дүрэм, журамд нийцүүлэн тогтмол өгөх | Тухай бүр | ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжилтэн | ХАБЭА, ҮОХХСБКомисс | Зааварчилгаа өгсөн байна |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6 | Цар тахалтай холбогдож гарсан Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрийг тухай бүр хэрэгжүүлж ажиллах | Тухай бүр | ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжилтэн | ХАБЭА, ҮОХХСБКомисс | Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр гарсан Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрийг тухай бүр хэрэгжүүлж ажилласан байна |
| 7 | Ковид- 19 цар тахлын үед аюулгүй ажиллах ерөнхий зааварчилгаа MNS ISO/PAS 45005:2021 стандартыг ХАБЭА-н үйл ажиллагаанд мөрдөх | Тухай бүр | ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжилтэн | ХАБЭА, ҮОХХСБКомисс | MNS ISO/PAS 45005:2021 стандартыг ХАБЭА-н үйл ажиллагаанд мөрдсөн байна |
| 8 | Гамшгаас хамгаалах штаб байгуулах, үйл ажиллагааг тогтмолжуулах | I улирал | ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжилтэн | Гамшгаас хамгаалах штаб | Төвийн хэмжээнд гамшгаас хамгаалах штабыг байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулсан байна |
| 9 | Цар тахлын үед болзошгүй эрсдэлээс сэргийлэх байгууллагын дотоод үйл ажиллагаанд мөрдөх журам боловсруулж батлуулах | I улирал | ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжилтэн | ЗСХ | Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд мөрдөх журмыг батлуулан, мөрдүүлсэн байна. |
| **Ажилтны эрүүл мэндийг хамгаалах ажлын хүрээнд:** | | | | | |
| 10 | Ажилтны стрессийн судалгаа хийх, түүний мөрөөр стрессийг арилгах арга замыг олох | II улирал | ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжилтэн | ХАБЭА, ҮОХХСБКомисс | Ажилтны стрессийн судалгаа хийж, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авсан байна |
| 11 | Ажлын байранд коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх халдваргүйтэл, ариутгалыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх | Тогтмол | ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжилтэн | ХАБЭА, ҮОХХСБКомисс, ЗСХ | Ажлын байранд тогтмол ариутгал халдваргүйтлийг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн байна |
| 12 | Коронавирусын халдвараас сэргийлэх, ажилтны аюулгүй байдлыг хангах ариутгал, хамгаалалтын нөөц бүрдүүлэх | I, II улирал | ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжилтэн | ЗСХ | Ажилтныг ковидын халдвараас сэргийлэх хамгаалах нэг удаагийн амны хаалт, ариутгалын бодисын нөөц бүрдүүлж, ажилтныг хангасан байна |
| 13 | Витаминжуулалтын аян зарлаж, нийт ажилтнуудыг витаминжуулах | II улирал | ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжилтэн | ЗСХ | Нийт ажилтныг витаминжуулсан байна |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 14 | Ажилтнуудыг эмнэлэгийн урьдчилсан үзлэгт бүрэн хамруулах, үзлэгийн мөрөөр эрүүл мэндийг хамгаалах ажлыг зохион байгуулах | II улирал | ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжилтэн | ЗСХ | Ажилтнуудыг эмнэлэгийн урьдчилсан үзлэгт хамруулж, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авсан байна |
| 15 | Ажлын байрны дасгал хөдөлгөөнийг тогтмол цагт хийж хэвшүүлэх /өглөө, өдөр, үдээс хойш 3 удаа дасгал хөдөлгөөн хийх/ | Тогтмол | ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжилтэн | ЗСХ | Ажлын байрны дасгал хөдөлгөөнийг тогтмол цагт хийж хэвшүүлсэн байна |
| **Ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд:** | | | | | |
| 16 | Компьютерийн хор саармагжуулах дэлгэцийн туяаны хамгаалт, наалтыг ажилтан бүрийн компьютерт байршуулах | I улирал | ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжилтэн | ЗСХ | Компьютерийн дэлгэцийн туяаны хамгаалалтыг ажилтан бүрийн компьютерт байршуулсан байна |
| 17 | Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх | II улирал | ХАБЭА,ҮОХХСБК | ЗСХ | Төвийн ажлын байрны цэвэр усны шугамд ус цэвэршүүлэгч холбож, ажилтныг цэвэр усаар хангасан байна. |
| 18 | Аюултай хог хаягдлыг ангилан хадгалах агуулахыг тохижуулах | I улирал | ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжилтэн | ЗСХ | Ажлын байранд аюултай хог хаягдлын агуулахыг тохижуулж, хог хаягдлыг ангилж хадгалсан байна. |
| 19 | Хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэл худалдан авах | I-II улиралд | ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжилтэн | ЗСХ | Албан томилолтоор ажиллахад шаардлагатай аюулгүй ажиллагааны шаардлага хангасан хувцас хэрэгсэлтэй болсон байна. |
| 20 | Аюул, ослоос урьдчилан сэргийлэх зааварчилгаа, дохио, санамж, анхааруулга, тэмдэг, тэмдэглэгээ, хаалт, хамгаалалтыг ажлын байранд байршуулах | Тогтмол | ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжилтэн | ХАБЭА,ҮОХХСБК | Аюул, ослоос урьдчилан сэргийлэх зааварчилгаа, дохио, санамж, анхааруулга, тэмдэг, тэмдэглэгээ, хаалт, хамгаалалтыг ажлын байранд байршуулсан байна. |
| 21 | Цар тахалын халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр ажлын байранд хүн хоорондын зай бариулах ажлыг зохион байгуулах | I улиралд | ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжилтэн | ХАБЭА,ҮОХХСБК | Ажлын байранд хүн хоорондын зай бхйриулах, ширээ сандлын зайг холдуулах, сүлжээний утас цахилгаан утасны холболтыг нэмэгдүүлэх, ил гарсан |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | утаснуудын далдалж аюулгүй байдлыг хангасан байна |
| **Дотоод хяналт шалгалтын хүрээнд:** | | | | | |
| 22 | Хоёр шатны хяналтын үзлэг хийх, үзлэгийн мөрөөр гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээг зохион байгуулах | Сар бүр | ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжилтэн | ХАБЭА,ҮОХХСБК | Хоёр шатны хяналтыг зохион байгуулж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгасан байна |
| 23 | Галын аюулгүй байдлыг хангуулах | I, IV улиралд | ХАБЭА,ҮОХХСБК | ХАБЭА,ҮОХХСБК | Байгууллагын хэмжээнд галын аюулгүй байдлыг хангаж, галын аюулгүй байдлын самбар байршуулан, галын аюулгүй байдлын талаар сургалт мэдээллийн арга хэмжээг зохион байгуулсан байна |
| 24 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хуулийн мэдлэгийг шалгах шалгалт авах | I, IV улиралд | ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжилтэн | ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжилтэн | Хуулийн мэдлэгийг шалгах шалгалтыг тухай бүр авч, мэдлэгийг бататгах арга хэмжээг зохион байгуулсан байна |
| **Ажилчдыг чадваржуулах, ХАБЭА-н сургалт зохион байгуулах ажлын хүрээнд** | | | | | |
| 25 | "Нэн түрүүнд-ХАБЭА"-хөгжөөнт дэвжээ тэмцээнийг зохион байгуулах | II улиралд | ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжилтэн | ХАБЭА,ҮОХХСБК | Хөгжөөнт тэмцээнийг зохион байгуулсан байна |
| 26 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хуулийг сурталчлан таниулах сургалт зохион байгуулах | Улирал бүр | ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжилтэн | ЗСХ | Сургалт мэдээллийн арга хэмжээг тухай бүр зохион байгуулсан байна |
| 27 | Гамшгаас хамгаалах тухай хуулийг сурталчлах сургалт мэдээлэл зохион байгуулах | IIулирал | ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжилтэн | ХАБЭА,ҮОХХСБК, ЗСХ | Гамшгаас хамгаалах тухай хуулийг сурталчилсан байна |
| 28 | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөл, хурц хордлогыг судлан бүртгэх дүрмийн танилцуулга, сургалт зохион байгуулах | IV улирал | ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжилтэн | ХАБЭА,ҮОХХСБК | Сургалт мэдээллийн арга хэмжээг зохион байгуулсан байна |
| 29 | Нийт ажилтанд ХАБЭА-н сургалт зохион байгуулах | Улирал бүр | ХАБЭА-н асуудал хариуцсан мэргэжилтэн | Нийт ажилтнууд | Нийт ажилтанд ХАБЭА-н сургалт зохион байгуулсан байна |
| **ХАБЭА-н чиглэлээрх олон нийтийн ажлын хүрээнд:** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 30 | ГТХЗНТ-ийн нэрэмжит Налайх дүүргийн "Инженер- Ирээдүй" тегелд мод тарих аян өрнүүлэх | II ,III улирал | ЗСХ | Нийт ажилтнууд | Мод тарих аянд нийт ажилтнуудыг хамруулсан байна |
| 31 | "Хөдөлгөөний дутагдлаас сэргийлье" сэдэвт явган аялал зохион байгуулах | Улирал бүр | ЗСХ | Нийт ажилтнууд | Явган аялалд нийт ажилтнуудыг хамруулсан байна |
| 32 | Зам, тээврийн салбарын 5 төрөлт спортын тэмцээнд нийт ажилтныг оролцуулах | II улиралд | ЗСХ | Нийт ажилтнууд | Нийт ажилтныг спортын тэмцээнд хамруулсан байна |
| 33 | Хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, тогтмол дасгал хөдөлгөөн хийх зорилгоор спорт зааланд тоглох, нөхөрсөг тэмцээн зохион байгуулах | II, IV улирал | ХАБЭА,ҮОХХСБК | Нийт ажилтнууд | Хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор спорт арга хэмжээнүүдийг зохион байгуулсан байна |

____o0o____